



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/03/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Чанцалдулам
Утас: 261740 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Аудитор: С.Отгонхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

Агуулга	1
1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө	14
3.5.2 Авлага	14
3.5.3 Урьдчилгаа	15
3.5.4 Бараа материал	15
3.5.5 Үндсэн хөрөнгө	15
3.5.6 Өр төлбөр	16
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.6.1 Төсвийн төлөвлөлт	17
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.6.3 Нэмэлт төсөв	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Харьяа байгууллагууд	21
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч	21
4.2.1 Төлбөрийн акт	21
4.2.2 Албан шаардлага	21
4.3 Зөвлөмж	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БТГ	Байнгын төлөөлөгчийн газар
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
ЕКГ	Ерөнхий консулын газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
КГ	Консулын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХШУДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар
ЭСЯ	Элчин сайдын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Н.АНХБАЯР ТАНАА

2022, 03.25 № 07/703
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,715,371.7	7,223,758.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,870,972.8	1,061,860.9
33	АВЛАГА	3,830,910.2	2,357,827.8
34	УРЬДЧИЛГАА	202,265.3	202,012.1
35	БАРАА МАТЕРИАЛ	2,811,223.4	3,602,057.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	328,265,888.7	409,934,953.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	328,265,888.7	409,934,953.0
39100	Газар	33,342,495.7	38,393,796.5
39200	Биет хөрөнгө	270,802,906.4	345,556,678.6
39300	Биет бус хөрөнгө	24,120,486.5	25,984,477.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	337,981,260.4	417,158,711.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	426,091.0	352,812.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	426,091.0	352,812.7
41300	Өглөг	418,684.8	352,770.0
41400	Урьдчилж орсон орлого	7,406.2	42.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	337,555,169.4	416,805,898.5
51	Засгийн газрын хувь оролцоо	337,555,169.4	416,805,898.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	189,945,563.1	189,945,563.1
51200	Хуримтлагдсан үр дүн	(91,137,980.8)	(103,030,699.6)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	251,200,863.6	251,200,863.6
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	(12,453,276.5)	78,690,171.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	337,981,260.4	417,158,711.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	85,992,923.4	95,365,429.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,381,337.8	6,792,113.3
120	Нийтлэг татварын бус орлого	6,381,337.8	6,792,113.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	79,611,585.5	88,573,316.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	97,261,072.8	105,681,163.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	97,086,768.9	105,614,322.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,783,607.4	87,116,715.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,433,297.7	32,951,274.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	799,828.8	698,763.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,345,474.2	16,370,332.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,880,843.2	1,952,780.5
2105	Нормативт зардал	27,660.2	10,229.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	795,146.5	1,839,608.2
2107	Томилолт, зочны зардал	2,708,187.8	4,865,527.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,506,469.3	9,274,740.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,286,699.7	19,153,458.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,303,161.4	18,497,607.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	174,303.9	66,840.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(11,268,149.4)	(10,315,733.3)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	164,050.5	109,701.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	382,295.3	299,971.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(11,486,394.2)	(10,506,003.2)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,401,721.7	0.0	335,401,721.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	13,001,334.2	0.0	13,001,334.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	348,403,055.9	0.0	348,403,055.9
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	638,507.7	0.0	638,507.7
9	Тайлант үеийн үр дүн	-11,486,394.2	0.0	-11,486,394.2
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,555,169.4	0.0	337,555,169.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,386,715.6	0.0	-1,386,715.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	336,168,453.8	0.0	336,168,453.8
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	91,143,448.0	0.0	91,143,448.0
19	Тайлант үеийн үр дүн	-10,506,003.2	0.0	-10,506,003.2
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	416,805,898.5	0.0	416,805,898.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	85,776,087.7	94,568,442.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,164,502.2	5,995,126.2
120	Нийтлэг татварын бус орлого	6,055,037.3	5,995,126.2
122	Тусламжийн орлого	109,464.9	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	79,611,585.5	88,573,316.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	82,553,125.8	89,433,776.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,553,125.8	89,433,776.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,249,964.3	70,930,268.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,962,828.3	32,781,254.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	799,828.8	764,313.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,370,653.6	16,427,127.9
2104	Хангамж, бараа материалын зардал	1,851,998.6	1,871,002.4
2105	Нормативт зардал	19,515.6	19,435.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	876,848.9	2,209,462.5
2107	Томилолт, зочны зардал	2,714,179.8	4,803,634.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,579,501.0	9,328,917.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,074,609.7	2,725,120.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,303,161.4	18,503,508.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,222,962.0	5,134,665.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,024,300.9	6,690,698.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,024,300.9	6,690,698.2
2200	Дотоод эх үүсвэрээр	5,024,300.9	6,690,698.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,024,300.9)	(6,690,698.2)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(31,438.7)	(253,079.6)
14	Бусад эх үүсвэр	198,311.4	58,748.3
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	229,750.1	311,827.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(1,832,777.6)	(1,809,111.8)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,703,750.4	2,870,972.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,870,972.8	1,061,860.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	87,836,967,200.00	75,957,747,547.07	11,879,219,652.93	86.5
УРСГАЛ ЗАРДАЛ	83,487,567,200.00	71,705,121,856.02	11,782,445,343.98	85.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	83,022,006,600.00	71,515,736,498.02	11,506,270,101.98	86.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,611,819,200.00	32,291,897,511.44	2,319,921,688.56	93.3
Үндсэн цалин	34,611,819,200.00	32,291,897,511.44	2,319,921,688.56	93.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	956,316,100.00	756,756,227.78	199,559,872.22	79.1
Тэтгэврийн даатгал	956,316,100.00	756,756,227.78	199,559,872.22	79.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,141,932,600.00	16,015,327,896.45	2,126,604,703.55	88.3
Гэрэл, цахилгаан	1,185,600,000.00	903,665,608.66	281,934,391.34	76.2
Түлш, халаалт	1,436,288,800.00	1,196,639,034.14	239,649,765.86	83.3
Цэвэр, бохир ус	750,806,300.00	466,776,607.82	284,029,692.18	62.2
Байрны түрээс	14,769,237,500.00	13,448,246,645.83	1,320,990,854.17	91.1
Хангамж, бараа материалын зардал	2,449,982,600.00	1,853,523,667.44	596,458,932.56	75.7
Бичиг хэрэг	312,826,000.00	209,047,271.76	103,778,728.24	66.8
Тээвэр, шатахуун	930,524,800.00	713,037,272.60	217,487,527.40	76.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	905,186,000.00	745,673,008.32	159,512,991.68	82.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	301,445,800.00	185,766,114.76	115,679,685.24	61.6
Нормативт зардал	100,868,500.00	19,434,995.89	81,433,504.11	19.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,868,500.00	19,434,995.89	81,433,504.11	19.3
Эд хогшил, урсгал засварын зардал	3,918,119,700.00	3,429,686,516.93	488,433,183.07	87.5
Багаж, техник, хэрэгсэл	1,354,444,900.00	1,182,552,590.10	171,892,309.90	87.3
Урсгал засвар	2,563,674,800.00	2,247,133,926.83	316,540,873.17	87.7
Томилолт, зочны зардал	6,408,524,100.00	4,714,694,800.23	1,693,829,299.77	73.6
Гадаад албан томилолт	4,223,311,200.00	3,281,063,937.08	942,247,262.92	77.7
Зочин төлөөлөгч хүлээн авах	2,185,212,900.00	1,433,630,863.15	751,582,036.85	65.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,331,080,800.00	9,746,888,157.83	2,584,192,642.17	79.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,530,609,900.00	961,525,630.66	1,569,084,269.34	38.0
Даатгалын үйлчилгээ	9,413,469,400.00	8,574,579,176.22	838,890,223.78	91.1
Газрын төлбөр	28,838,700.00	9,370,140.81	19,468,559.19	32.5
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	358,162,800.00	201,413,210.14	156,749,589.86	56.2
Бараа үйлчилгээний бусад зардал	4,103,363,000.00	2,687,526,724.03	1,415,836,275.97	65.5
Бараа үйлчилгээний бусад зардал	516,286,800.00	143,271,945.84	373,014,854.16	27.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,587,076,200.00	2,544,254,778.19	1,042,821,421.81	70.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	465,560,600.00	189,385,358.00	276,175,242.00	40.7
Бусад урсгал шилжүүлэг	465,560,600.00	189,385,358.00	276,175,242.00	40.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	453,040,600.00	183,925,358.00	269,115,242.00	40.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,520,000.00	5,460,000.00	7,060,000.00	43.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,349,400,000.00	4,252,625,691.05	96,774,308.95	97.8
Их засвар	3,000,000,000.00	2,939,224,686.02	60,775,313.98	98.0
Тоног төхөөрөмж	1,349,400,000.00	1,313,401,005.03	35,998,994.97	97.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	87,836,967,200.00	79,858,968,748.90	7,977,998,451.10	90.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	87,836,967,200.00	79,858,651,869.90	7,978,315,330.10	90.9
Улсын төсвөөс санхүүжих	87,836,967,200.00	79,858,651,869.90	7,978,315,330.10	90.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	316,879.00	-316,879.00	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	316,879.00	-316,879.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	2,870,972,765.78	-2,870,972,765.78	

Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,061,860,942.82	-1,061,860,942.82	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	49	49	0	100.0
Төсвийн байгууллага	49	49	0	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	496	496	0	100.0
Удирдах ажилтан	49	49	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	241	241	0	100.0
Үйлчлэх ажилтан	206	206	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,080,405,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,080,405,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,080,405,400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	489,357,308.00
210101	Үндсэн цалин	-	489,357,308.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	7,557,308.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	7,557,308.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	411,800,000.00
210301	Гэрэл, цахилгаан	-	12,400,000.00
210302	Түлш, халаалт	-	0.00
210303	Цэвэр, бохир ус	-	2,400,000.00
210304	Байрны түрээс	-	397,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	18,800,000.00
210401	Бичиг хэрэг	-	5,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	8,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	4,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	6,400,000.00
210604	Урсгал засвар	-	6,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	88,940,000.00
210701	Гадаад албан томилолт	-	33,340,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	55,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	19,957,281.26
210803	Даатгалын үйлчилгээ	-	15,957,294.63
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	3,999,986.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	37,593,476.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	37,593,476.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	13.37
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	13.37
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	13.37
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,080,405,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,080,405,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,080,405,400.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж, нэмж авлаг өглөг үүсгэхгүй байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хооронд Аудитын хоёрдугаар газрын аудитор С.Отгонхорлоо гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг ахлах аудитор П.Чанцалдулам, хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Дипломат төлөөлөгчийн газар нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 08/1066 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дипломат төлөөлөгчийн газар нь “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчныг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тус эрхэм зорилгоо хэрэгжүүлэхдээ Дипломат төлөөлөгчийн газрууд нь Дипломат албаны тухай хуулийн хүрээнд Монгол Улсын гадаад харилцааг Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлийг улс орны болон дэлхий дахины шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, хоёр ба олон талын харилцааны асуудлаар хэлэлцээ хийх, гэрээ хэлцэл байгуулах, тохиролцсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах судалгаа хийх, холбогдох байгууллагад танилцуулах, хилийн чанадад Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах, гадаадад суугаа Монгол Улсын иргэдэд консулын болон нотариатын үйлчилгээ үзүүлэх, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг хөтлөх үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагааны чиглэл: Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Монгол Улсын хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад сурталчилгаа, соёлын харилцааг хөгжүүлэх, хилийн чанад дах монгол иргэд, сургууль, цэцэрлэг, холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх;

Дипломат төлөөлөгчийн газруудын санхүүгийн тайланг Санхүүгийн тооцоолох группын “Асоулус” программаар гаргаж, валютын хөрвүүлэлт, санхүүгийн нэгтгэсэн тайланг “Талст”

программыг нэвтрүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, болон холбогдох тодруулга тайлангуудыг тус тус бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол ;
- Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” 190 дугаар тушаал;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль Монгол Улсын Их Хурлаар 2021 оны 6 дугаар сарын 11-нд батлагдаж, 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон гадаад валютын хөрвүүлгийг хаалтын ханшаар тооцохоор тусгаж хэрэгжүүлсэн байна.

Гадаад харилцааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй, Монгол Улсаас гадаад орнуудад суугаа Парис дахь ЭСЯ-ны 2019-2020 оны үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус, Брюссель дэх ЭСЯ-ны 2020-2021 оны үйл ажиллагаанд төлөвлөгөөт аудитыг тус тус хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 105,681.1 сая төгрөгөөс нийт зардлын 1.0 хувиар буюу 1,056.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,177.5 сая төгрөгөөр буюу 23.4 хувиар нэмэгдсэн байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,061.9 сая төгрөг болж, 1,809.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, Бууралт/-
Касст байгаа бэлэн мөнгө	635,785.4	179,197.2	(456,588.2)
Гадаад валют	635,785.4	179,197.2	(456,588.2)
Банканд байгаа бэлэн мөнгө	2,189,520.6	881,239.4	(1,308,281.2)
Гадаад валют	2,189,520.6	881,239.4	(1,308,281.2)
Замд яваа мөнгөн хөрөнгө	45,666.7	1,424.4	(44,242.4)
Дүн	2,870,972.7	1,061,860.9	-1,809,111.8

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дипломат төлөөлөгчийн газруудын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 179.2 сая төгрөг касст буюу бэлнээр, 881.2 сая төгрөг арилжааны банкны харилцах дансанд байршиж байна. Мөн замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.4 сая төгрөг нь Эрхүү дэх Консулын газрын харилцах данснаас тогтмол зардлын үлдэгдэл төлбөрийг шилжүүлсэн байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 2,357.8 сая төгрөг болж, 1,473.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас санхүүжилтийн авлага	-	5,900.9	(5,900.9)
Байгууллагаас авах авлага	3,400,198.6	1,922,179.0	(1,478,019.5)
Хувь хүмүүсээс авах авлага	430,711.6	429,748.0	(963.7)
Дүн	3,830,910.2	2,357,827.9	(1,473,082.3)

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурсан нь Астана дахь ЭСЯ-д барилга, газрын маргаантай холбоотой олон жилийн өмнө үүссэн 1,641.5 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлээс хассан, Вена дэх ЭСЯ-ны 40.9 сая, Нью-Йорк БТГ-ын 18.9 сая төгрөгийн байрны барьцааны төлбөрүүдийг чөлөөлсөнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд 3-аас дээш жилийн насжилттай 900.2 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд: Москва дахь ЭСЯ-ны ажилтнуудын байрны түрээсийн төлбөрөөс үүссэн 482.4 сая, Варшав дахь ЭСЯ-ны байрны барьцаа, шүүхийн зардал 86.6 сая, Брюссель дэх ЭСЯ-ны 40.7 сая, Вена дэх ЭСЯ-ны 45.7 сая, Ром дахь ЭСЯ-ны 130.1 сая, Сингапур ЭСЯ-ны

87.5 сая, Эл-Кувейт дэх ЭСЯ-ны 11.2 сая, Нью-Йорк БТГ-ын 29.3 сая, Женев дахь ЭСЯ-ны 38.0 сая, Сан-Франциско дахь Ерөнхий консулын газар 18.0 сая, Шанхай ДТГ-ын 32.9 сая төгрөгийн байрны барьцааны төлбөрүүд байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 202.0 сая төгрөг болж, өмнөх оноос 0.3 сая төгрөгөөр буурсан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Анкара дахь ЭСЯ-ны хамгаалалтын төхөөрөмжийн 17.1 сая, Вашингтон дахь ЭСЯ-ны агааржуулалтын засварын ажлын зардал 50.0 сая, Минск дэх ЭСЯ-ны 42.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн урьдчилгаа тус тус байна.

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 3,602.0 сая төгрөг болж, өмнөх оноос 790.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	945,417.3	911,097.1	(34,320.2)
Тусгай зориулалтын материал	930,844.8	901,607.4	(29,237.4)
Бэлэн бүтээгдэхүүн	14,572.5	9,489.7	(5,082.8)
Хангамжийн материал	1,865,806.2	2,690,960.3	825,154.1
Бичиг хэргийн материал	42,248.5	70,462.5	28,214.0
Аж ахуйн материал	166,744.3	259,153.1	92,408.8
Сэлбэг хэрэгсэл	83,390.3	147,930.8	64,540.5
Түлш, шатах тослох материал	22,169.8	19,231.5	(2,938.3)
Барилгын засварын материал	654.0	46.8	(607.2)
Хүнсний материал	214,930.3	341,841.0	126,910.7
Бусад хангамжийн материал	1,335,669.0	1,852,294.6	516,625.6
Дүн	2,811,223.5	3,602,057.4	790,833.9

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн өсөлт нь урсгал төсвөөс тайлант онд нийт 1,634.9 сая төгрөгийн материал худалдан авснаас шалтгаалсан байна. Өмнөх оноос бичиг хэргийн материал 28.2 сая, бусад хангамжийн материал 516.6 сая, хүнсний материал 126.9 сая, аж ахуйн материал 92.4 сая, сэлбэг хэрэгсэл 64.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 482,916.6 сая төгрөг болж, өмнөх оноос 106,874.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	33,342,495.7	38,393,796.5	5,051,300.8
Биет хөрөнгө	318,544,638.9	418,493,796.3	99,949,157.4
Барилга, байгууламж, орон сууц	301,182,973.9	390,278,218.6	89,095,244.7
Авто-тээврийн хэрэгсэл	9,408,428.3	14,618,484.3	5,210,056.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,116,152.9	5,509,047.5	2,392,894.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,492,498.9	7,500,542.8	3,008,043.9
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	6,079.0	69,098.8	63,019.8
Бусад үндсэн хөрөнгө	323,790.3	493,962.0	170,171.7
Ном	14,715.6	24,442.3	9,726.7
Биет бус хөрөнгө	24,155,137.9	26,029,057.5	1,873,919.6
Программ хангамж	49,287.1	52,960.5	3,673.4

Бусад биет бус хөрөнгө	24,105,850.8	25,976,097.0	1,870,246.2
Дүн	376,042,272.5	482,916,640.3	106,874,377.8

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9 ЭСЯ-д автомашин 1,349.4 төгрөгөөр худалдан авч, 9 ЭСЯ-ны барилгын их засварт 3,000.0 сая төгрөгийг зарцуулж, капиталжуулсан, ТӨБЗГ-ын 312 дугаар тогтоолоор Сангийн яамнаас Бээжин дэх ЭСЯ-д 58.0 сая төгрөгийн үнэтэй, 41.0 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй автомашиныг балансаас балансад шилжүүлсэн, Ром дахь ЭСЯ-ны лизингийн төлбөр нь дууссан автомашиныг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Мөн ТӨБЗГ-ын А-2/1276 дугаар албан бичгээр Бишкек дэх ЭСЯ, Прага дахь ЭСЯ-дын 12.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлсэн, 454 дүгээр тогтоолоор 32 ЭСЯ-ны 165.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 31 ЭСЯ-ны 105.0 сая төгрөгийн тавилга эд хогшлыг акталж данснаас хассан, ТӨБЗГ-ын 2021 оны 455 дугаар тогтоолоор 9 ЭСЯ-ны 444.0 сая төгрөгийн 10 автомашиныг акталж, 8 авто машиныг худалдах доод үнийн жишгээр худалдан санхүүжилтээс суутган тооцсон, 2 ЭСЯ-ны автомашин суугаа орны нөхцөл байдлаас шалтгаалан зарагдаагүй тул ТӨБЗГ-ын 730 дугаар тогтоолоор худалдах доод үнийг өөрчлөн дахин тогтоосон байна.

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах ТӨБЗГ-ын 2016 оны 239 дүгээр тогтоолоор Москва дахь ЭСЯ, 2020 оны 251 дүгээр тогтоолоор Вьентьян дахь ЭСЯ-ны автомашинуудыг тус тус акталж, худалдах үнээр нь санхүүжилтээс суутган тооцсон байна.

3.5.6 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 352.8 сая төгрөг болж, өмнөх оноос 65.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өссөн/+, Буурсан/-/
Богино хугацаат өр төлбөрийн дүн	418,684.7	352,770.0	65,914.7
Бусад өглөг	418,684.7	352,770.0	65,914.7
Байгууллагад төлөх өглөг	366,246.7	314,920.2	(51,326.5)
Хувь хүмүүст төлөх өглөг	52,438.0	37,849.8	(14,588.2)
Урьдчилж орсон орлого	7,406.2	42.7	(7,363.5)
Бусад урьдчилж орсон орлого	7,406.2	42.7	(7,363.5)
Нийт дүн	426,090.9	352,812.7	(113.3)

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өглөгийн үлдэгдэл өмнөх оноос 65.9 сая төгрөгөөр буурсан нь Брюссель дэх ЭСЯ-ны халаалтын зуухны үлдэгдэл 41.7 сая, Ром дахь ЭСЯ-ны АСЕМ-ын үеийн гадны байгууллагад шилжүүлэх төлбөрийн 63.2 сая төгрөгийн өглөгүүдийг тус тус тайлант онд барагдуулсантай холбоотой байна.

ДТГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд 3-с дээш жилийн насжилттай 130.9 сая төгрөгийн өглөг байна. Тухайлбал: Варшав дахь ЭСЯ-ны эзэн холбогдогч нь тодорхойгүй, программд дансны бичилт буруу хийснээс үүссэн зэрэг 125.5 сая, Женев дэх Байнгын төлөөлөгчийн газар 5.4 сая төгрөгийн 2017 оноос өмнө үүссэн өглөгүүд байна.

Лондон дахь ЭСЯ-ны виз болон консулын үйлчилгээний орлого урьдчилж орсон, тус үйлчилгээг үзүүлснээр тайлант онд урьдчилж орсон орлого 7.3 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.7 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 416,805.9 сая төгрөг болж, өмнөх оноос 79,250.7 сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/МЯНГАН ТӨГРӨГ/ Өсөлт/+, Бууралт/-
Засгийн газрын оруулсан капитал	189,945,563.1	189,945,563.1	-
Хуримтлагдсан үр дүн	(91,137,980.7)	(103,030,699.6)	(11,892,718.8)
Өмнөх үеийн үр дүн	(91,137,980.7)	(92,524,696.4)	(1,386,715.6)
Тайлант үеийн р дүн	-	(10,506,003.2)	(10,506,003.2)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	251,200,863.6	251,200,863.6	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	(12,453,276.5)	78,690,171.2	91,143,447.9
Нийт дүн	337,555,169.3	416,805,898.5	79,250,729.2

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд гадаад валютын хөрвүүлэлт 91,143.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хөрөнгийг хаалтын ханшаар хөрвүүлэн тооцож тайлагнасанатай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 204,901.1 сая төгрөгөөр үүнээс урсгал төсөвт 101,365.2 сая, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардалд 103,535.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн саналаас цалингийн зардлыг 3,369.3 сая, НДШ 185.6 сая, байр ашиглалттай холбоотой зардлыг 4,558.8 сая, хангамж бараа материалын зардлыг 1,026.2 сая, эд хогшил, урсгал засвар 1,019.8 сая, гадаад томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 5,239.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,132.0 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,322.0 сая төгрөгөөр буюу урсгал төсвийг нийт 13,283.3 сая төгрөгөөр бууруулсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 87,836.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 83,487.6 сая төгрөгийг урсгал, 4,349.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар тус тус батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагааны төсөвт 83,207.5 сая, хөрөнгийн санхүүжилтэд 4,285.4 сая төгрөг, нийт 87,492.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 71,705.1 сая, хөрөнгийн зардалд 4,252.6 сая, нийт 75,957.7 сая төгрөгийг зарцуулж 7,640.2 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Монгол Улсаас гадаад орнуудад суугаа Элчин сайдын яамд нь гүйцэтгэлээр үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 4,166.5 сая, түрээс болон бусад орлогоос 1,828.5 сая, нийт 5,995.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл болон эхний үлдэгдлээс 4,678.9 сая төгрөгийг суутган тооцуулж, нийт 10,674.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Дипломат төлөөлөгчийн газруудын цалингийн зардлаас 2,319.9 сая, НДШ 199.5 сая байр ашиглалтын зардлаас 2,126.6 сая, хангамж бараа материалын зардлаас 596.5 сая, эд хогшил, урсгал зардлаас 488.4 сая, томилолт зочны зардлаас 1,693.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 2,584.2 сая, бараа үйлчилгээний зардал 1,415.8 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалтын 16 төсөл, арга хэмжээнд 4,349.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 4,252.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт-7 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт -ийн хувь
	Код	Нэр				
Гадаад улс орнууд дахь дипломат үйл ажиллагаа /70301/						
1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	81,968,981.8	70,978,098.5	10,990,883.2	86.5
		Үйл ажиллагааны урсгал зардал	81,968,981.8	70,978,098.5	10,990,883.2	86.5
2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	7,297.2	0.0	7,297.2	-
		Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,297.2	0.0	7,297.2	-
3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	1,041,832.1	537,638.0	504,194.1	51.6
		Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,041,832.1	537,638.0	504,194.1	51.6
4	80312	Сургалт, семинар	3,895.5	0.0	3,895.5	-
		Бараа үйлчилгээний бусад зардал	3,895.5	0.0	3,895.5	-
5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	465,560.6	189,385.4	276,175.3	40.6
		Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн дэмжлэг	453,040.6	183,925.4	269,115.2	40.6
		Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,520.0	5,460.0	7,060.00	43.6
Улсын төсвийн хөрөнгө оруулалт			4,349,400.0	4,252,625.6	32.8	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Монгол Улс, Оросын Холбооны Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг хамтран тэмдэглэх арга хэмжээний зардалд 50.0 сая, Тайпей дэх Улаанбаатар хотын Худалдааны төлөөлөгчийн газрын санхүүжилтэд 1,030.4 сая төгрөг, нийт 1,080.4 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, НДШ-д 496.9 сая, байр ашиглалт холбоотой зардал 411.8 сая, хангамж бараа материалын зардалд 18.8 сая, эд хогшлын зардалд 6.4 сая, албан томилолт, зочин төлөөлөгчийн зардалд 88.9 сая, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 19.9 сая, бараа үйлчилгээний зардалд 37.5 сая, нийт 1.080.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайпей дэх Улаанбаатар хотын Худалдааны төлөөлөгчийн газрын санхүүжилт 1,030.4 сая төгрөгийг НЗДТГ-ын төсөвт төлөвлөн, зарцуулдаг бөгөөд зөвхөн санхүүгийн тайланд хүлээн авч тайлангийн нэгтгэлд авдаг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд хөтөлбөр арга хэмжээ, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 5 арга хэмжээний хэрэгжилт 38 ДТГ-уудыг үнэлж, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 71,706.0 сая төгрөг буюу 86.5 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Хилийн чанадад суугаа ДТГ-уудын ам.долларын нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан УСНББОУС 4 “Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө” 44-р зүйлийн (а) санхүүгийн байдлын тайлан бүрд толилуулсан хөрөнгө, өр төлбөр (зэрэгцүүлсэн тайлангууд хамаарна)-ийг тухайн санхүүгийн байдлын тайлангийн өдрөөрх хаалтын ханшаар хөрвүүлнэ, Сангийн сайдын 2017 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн валютыг тогтоох, өөрчлөх, санхүүгийн тайлан хөрвүүлэх журам” болон 2021 онд батлагдсан “Улсын секторын байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам”-д зааснаар байгууллага бүртгэлийн буюу гадаад валютаар бэлтгэсэн санхүүгийн тайлангийн хөрөнгө, өр төлбөрийг хаалтын ханшаар, орлогын дэлгэрэнгүй тайлангийн (бусад дэлгэрэнгүй орлогоос бусад) буюу санхүүгийн үр дүнгийн үзүүлэлтүүдийг ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар, бусад зүйлсийг түүхэн ханшаар тус хөрвүүлэн тайлагнана гэж заасны дагуу хөрвүүлэн нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэсэн байна.

Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, холбогдох стандарт, журмын дагуу тайлант онд бараа материалыг хаалтын ханшаар тооцон хөрвүүлснээс бараа материал 504.1 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийг хаалтын ханшаар тооцон хөрвүүлснээр үндсэн хөрөнгө 96.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж тайлагнасан байна.

Тайлант оны Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтөд дараах бичилтүүдийг хийсэн байна.

Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2006 онд хийсэн дуусаагүй барилгыг Нурсултан дахь Элчин сайдын яамны авлагын дансанд бүртгэлтэй авлагыг барагдуулахаар тайлант онд Сангийн яамны 2021 7/4618 дугаартай албан бичгийг үндэслэн ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, Гадаад харилцааны сайдын 2021 А/45 дугаар тушаалаар данснаас хассан;
- Сөүл дэх ЭСЯ-ны буруу тооцож өглөг үүсгэсэн визийн орлого, Эль-Кувейт ЭСЯ-ны буруу тооцоолсон элэгдлийн зардал, Ром дэх ЭСЯ-ны санхүүжилтээс суутгасан тооцсон өглөг, Женев дэх байнгын төлөөлөгчийн газар нь ГХЯ-аас авлагаар бүртгэсэн Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын буудлын төлбөр, Бусан дахь Консулын газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын томилолтын зардал зэрэг ажил гүйлгээг тус тус залруулсан.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд нийт 172,700.7 сая төгрөгийн 273 мэдээллийг хугацаанд нь байршуулсан. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн ажилласан байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгдээгүй.

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт 100.0 хувь, 3 албан шаардлага, 1 зөвлөмжийн хэрэгжилт тус бүр 95.00 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт-8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	97,300.0	1	97,300.0	-	-	100.00
Албан шаардлага	3	2,490,500.5	3	2,490,500.5	-	-	95.00
Зөвлөмж	1	18,200.0	1	18,200.0	-	-	95.00
Нийт дүн	5	2,606,000.0	3	2,606,000.0	-	-	96.60

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хилийн чанад дахь ЭСЯ, Дипломат төлөөлөгчийн газруудын 48 байгууллагын тайланг нэгтгэсэн. Эдгээр газрууд нь 2018 сүүлийн хагас жил, 2019-2021 оны санхүүгийн тайлангуудад аудит хийгээгүй, ТШЗ-ийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд түүвэрт хамруулан аудит хийлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн 83,847.2 сая төгрөг буюу 86.4 хувийг хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын төсвийн дүн эзэлж байна.

Дипломат төлөөлөгчийн газруудад төсвийн хөрөнгөөс зарцуулдаг байр ашиглалтын зардал, байрны барьцааны авлага, өглөгийн асуудлыг дараагийн аудитад хамруулан нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хилийн чанад дахь ЭСЯ, Дипломат төлөөлөгчдийн газруудын 48 ТШЗ-ын санхүүгийн аудит хийгээгүй тайланг нэгтгэсэн тул зөрчлийн нэгтгэл байхгүй.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар нийт 152.4 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 98.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 47.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 5.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт 53.8 сая төгрөгийг алдаа, зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 792.6 сая төгрөгөөс бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.2.1 Төлбөрийн акт

1. Илрүүлэлт:

Монгол Улсаас хилийн чанд дахь суугаа элчин сайдын яамдын 2021 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Дипломат төлөөлөгчийн газруудад олгох санхүүжилтээс суутган тооцоогүй байна. Үүнд: Абу Даби дахь Элчин сайдын яам 4,338.17 ам.доллар, Владивосток дахь Худалдааны төлөөлөгчийн газар 3,857.80 ам.доллар, Манжуур дахь Консулын газар 2,136.84 ам.доллар, Минск дэх Элчин сайдын яам 24,270.95 ам.доллар буюу нийт 98.6 сая төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.2.2 Албан шаардлага

2. Илрүүлэлт:

Брюссель дахь Элчин сайдын яам нь 2021 оны батлагдсан төсвийг 16,836.63 ам.доллар буюу 47.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

3. Илрүүлэлт:

Дипломат төлөөлөгчийн газар нь төсвийг зохистой удирдаагүй, нийгмийн даатгалын шимтгэлд 5.9 сая төгрөгийг шилжүүлсэн ч гүйлгээ буцаж орсноор Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлага үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдах, гүйлгээ гарсан тухай бүр тооцоог хийж байх, авлага, өр төлбөрийг нэмж үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 25 № 140/А0170076

Улаанбаатар хот

АХГ-2022/05/НА-СТА-ТТЗ
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2 заалтын дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсаас хилийн чандад суугаа элчин сайдын яамдын 2021 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Дипломат төлөөлөгчийн газруудад олгох санхүүжилтээс суутган тооцоогүй байна. Үүнд: Абу Даби 4,338.17 ам.доллар, Владивосток 3,857.80 ам.доллар, Манжуур 2,136.84 ам.доллар, Минск 24,270.95 ам.доллар буюу нийт 98,579,191.49 төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Улсын төсөвт татан төвлөрүүлээгүй төсвийн хэмнэлтийн 98,579,191.49 /ерэн найман сая таван зуун далан есөн мянга нэг зуун ерэн нэгэн/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

АУДИТОР

С.ОТГОНХОРЛОО

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Т-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2022\0325 Auditin 2 Gazar-70.Docx

0001090318



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 662/А0170076

Улаанбаатар хот

АХП-2022/03/НА-СТА-773

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2 заалтын дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дипломат төлөөлөгчийн газрын харьяа Брюссель дахь Элчин сайдын яам нь 2021 оны батлагдсан төсвийг 16,836.63 ам.доллар буюу 47,972,441.49 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, батлагдсан төсөвт багтаан зардал гаргах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа, Нягтлан бодогч С.Алтангэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

С.ОТГОНХОРЛОО

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

10.10.10.20\Bichig_Kherem\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-292.Docx

0001031535

Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Дипломат төлөөлөгчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын алдаа, зөрчил

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																	
1	Дипломат төлөөлөгчийн газар	АХГ-2022/03/НА-СТА-ТТЗ	Монгол Улсаас хилийн чандад суугаа элчин сайдын яамдын 2021 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Дипломат төлөөлөгчийн газруудад олгох санхүүжилтээс суутган тооцоогүй байна. Үүнд: Абу Даби дахь ЭСЯ 4,338.17 ам.доллар, Владивосток дахь Худалдааны төлөөлөгчийн газар 3,857.80 ам.доллар, Манжуур дахь Консулын газар 2,136.84 ам.доллар, Минск дэх ЭСЯ 24,270.95 ам.доллар буюу нийт 98,579.2 мянган төгрөг байна.	Улсын төсөвт татан төвлөрүүлээгүй төсвийн хэмнэлтийн бүрэн төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.	1	98,579.2			1	98,579.2							
2	Дипломат төлөөлөгчийн газар	АХГ-2022/03/НА-СТА-ТТЗ	Дипломат төлөөлөгчийн газрын харьяа Брюссель дахь ЭСЯ нь 2021 оны батлагдсан төсвийг 16,836.63 ам.доллар буюу 47,972.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, батлагдсан төсөвт багтаан зардал гаргах албан шаардлага хүргүүлэх.	1	47,972.5					1	47,972.5					
3	Дипломат төлөөлөгчийн газар	АХГ-2022/03/НА-СТА-ТТЗ	ДТГ нь нийгмийн даатгалын шимтгэлд 5,900.8 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч уг ажил гүйлгээ буцаж орсноор Нийгмийн даатгалд өгөх өглөг, Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж, авлага өглөг дансыг зэрэг нэмэгдүүлэн тайлагнасан байна.	Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, нэмж үүсгэхгүй байх зөвлөмж өгөх.	1	5,900.8								1	5,900.8		
Дүн					3	152,452.5	-		1		98,579.2	1	47,972.5	-		1	5,900.8

